

## **БОЛОМЖ, СОРИЛТЫН ДУНДАХ ӨМНИЙН ГОВЬ**

**(Орон нутгийн судалгааны томилолтын тэмдэглэл)**

*И.Энхболд (ШУА-ийн ОУУХ)*

*Р.Төрдалай (ШУА-ийн ОУХХ)*

**Өмнөговь аймаг**

**2017.11.13-17**

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны салбарын судлаачид сүүлийн 3 жилийн хугацаанд “Дэлхийн эрдэс баялагийн зах зээл ба Монгол улс: Боломж ба сорилт” суурь судалгааны сэдэвт ажлыг хэрэгжүүлж дуусах шатандаа ороод байгаа билээ.

Суурь судалгааны хүрээнд манай судалгааны баг 2017 оны 11 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь Таван толгой нүүрсний ордын өнөөгийн ашиглалтын байдал, баяжуулах үйлдвэр, Монгол Улс-БНХАУ-ын хилийн боомт /Гашуун сухайт-Ганц мод/-ын үйл ажиллагаатай биечлэн танилцах зорилгоор судалгааны томилолтоор ажилласан юм.

Бид эхлээд Улаанбаатар хотоос 540 км зайд орших улсдаа томоохонд тооцогдох 17 мянган хүн амтай Цогтцэций сумын төвийг зорьсон юм. Говь нутаг цасгүй байсан ч жавартай салхи үлээсээр биднийг угтсан юм. Бид 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр тус сумын Тамгын газраар орж, дарга Батболд болон Тамгын газрын 9 ажилтантай уулзалт яриа хийв.

Тамгын газрын байрандаа засвар тохижилт хийж байгаа завгүй үетэй таарч тэр болгон ирээд байдаггүй “гэнэтийн урилгагүй зочид”-ын асуултад тулгамдуу хандаж байсан ч уулзалт ярилцлага боломжийн хэмжээнд өрнөсөн.

Цогтцэций сум нь 1924 онд байгуулагджээ. Таван толгойн уурхайн үйл ажиллагаа өнөөгийн түвшинд хүрч идэвхжихээс өмнө тус сум 2 мянга орчим хүн амтай байсан бол 2009 оноос хойш энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэж, өнөөгийн байдлаар байнгын суурин хүн ам 7 мянга гаруй, хөдөлгөөнт хүн амын тоо 10 мянгад хүрч нийтдээ 17 мянга гаруй хүн амтай болжээ.

Сумын удирдлагынхны өгүүлсэнээр өнөөдөр иргэний хөдөлгөөний идэвхтнүүдийн социал ертөнцөөр байнга тараадаг мэдээлэлд гардаг шиг хятад хүн Монгол Улсын иргэн болсон, монгол хүнтэй суусан тохиолдол огт байхгүй ажээ. Цогтцэций сум энэ оны байдлаар нийт 102 мянган толгой малтай. Гэхдээ сүүлийн жилүүдэд уул уурхайн үйл ажиллагаа идэвхжсэнээр малчдын бэлчээр ашиглалт ихээхэн хумигдаж, сумын нутаг дэвсгэрийн 60 гаруй хувьд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа нь малчдын өмнөх том бэрхшээл, шийдвэрлэх асуудал болоод байгаа юм байна. Үүнээс шалтгаалж сумын малчид өөр аймаг, сумдын нутаг руу дайжин нүүх тохиолдол гарч, газар бэлчээрийн маргаан олширсон гэнэ.

Цогтцэций сумын нутаг дэвсгэр дээр өнөөдөр “Эрдэнэс Таван толгой” төрийн өмчит ХК, хувийн хэвшлийн “Энержи ресурс” ХК, “Таван толгой” ХК зэрэг уул уурхайн гурван том компани, тэдгээрийг тойрсон олон жижиг аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаа аж. Тус сум нь өөрийгөө санхүүжүүлдэг ба Цогтцэций сум байтугай Өмнөговь аймгийн төсвийг бүрдүүлэхэд орон нутгийн иргэдийн дунд “Бага Таван толгой”, “Орон нутгийн Таван толгой” хэмээн нэршдэг “Таван толгой” ХК жинтэй хувь нэмэр оруулдаг байна.

Харин “Эрдэнэс Таван толгой” ХК, “Энержи ресурс” ХК нь улсын төсөвт ихээхэн хэмжээний татвар төвлөрүүлдэг гэдгийг хэн хүнгүй л мэднэ. Уул уурхайгаас гадна аймгийн хэмжээнд үл хөдлөх хөрөнгийн татвар, автомашины татварууд нь мөн орон нутагтаа төвлөрдөг байна. Өнөөгийн байдлаар уул уурхайн тээвэрлэлт хийдэг 30 гаруй компани байдгаас 10 гаруй компани нь Өмнөговь аймгийн дугаартай үйл ажиллагаа явуулж, татвараа төлдөг бөгөөд жилд ойролцоогоор 630 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Говийн мөнхийн бэрхшээлтэй зүйл бол усны асуудал байсаар ирсэн. Харин “Энержи ресурс” ХК нь Цэций хороолол, Наймтын хөндий хэмээх Цогт-Овоо, Цогт-Цэций сумын хилийн заагт орших газраас гүний цэвэр ус татаж чадсан байна. Энэхүү цэвэр усны шугамнаас 2015 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2.3 км цэвэр усны шугамыг хамгийн ойр хэсгээс нь сумын төв рүү татжээ.

Сумын Тамгын газрын ажилтнуудтай уулзсаны дараа сумын төвөөс нэлээд явсаар орон нутгийн Таван толгой хэмээн нэрлэдэг “Таван толгой” ХК-ийн удирдлагатай уулзахаар очсон юм. Үүдээр нь ороод жижүүрт нь судалгааны ажлаар явж байгаа тухайгаа хэлэхэд биднийг найрсагаар угтан авч захирал Д.Сэддоржтой уулзуулсан юм. Тэрээр компанийхаа түүх, өнөөгийн үйл ажиллагаа, цаашдын зорилтын талаар дэлгэрэнгүй танилцуулсан. Д.Сэддорж захирлын зүгээс биднийг ШУА-аас судалгаа шинжилгээний ажлаар зочилж буй анхны тохиолдол боллоо гэж өгүүлсэн. Түүний танилцуулга яриа болон орон нутгийн “Таван толгой” ХК-ийн үйл ажиллагааны тухай дор товч өгүүлье.

### **“Тавантолгой” ХК**

Тавантолгойн ордын коксжих нүүрс нь дэлхийд нөөцийн хэмжээгээр эхний 10-т багтдаг. Үүнээс IV давхаргын коксжих нүүрсний баяжмалын гарц нь 66.9%-тай байгаа нь Канад, Австралийн дэлхийн зах зээлд нийлүүлдэг нүүрснээс коксжих чанараас давуу байдаг байна. Тус хэсгийн ашиглалтын уул-геологийн нөхцөл энгийн, нүүрсний давхарга нь бага гүнд тогтсон, унал бага учир хөрс хуулалтын ажил бусад уурхайнуудтай харьцуулахад 2-3 дахин бага байдаг ажээ. Тавантолгойн орд нь дэд бүтцээс нэлээд алслагдсан хэдий ч 6.5 тэрбум тонн гаруй нөөцтэй. Үүнээс 4-р хэсгийн пласт нь ордын төвд, нөхцөл нь хамгийн сайн, нөөцийн хувьд одоогийн хүчин чадлаар ажиллавал 100-аас дээш жил үргэлжлэх боломжтой. Ордыг 1966 оноос эхэлж ил уурхайгаар ашиглаж, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн төв болон ойролцоох сумдын нүүрсний хэрэгцээг хангаж иржээ.

“Тавантолгой” ХК нь 51 хувийг төр, 49 хувийг нийтэд хувьцаа болгон гаргасан бөгөөд 23 орны иргэд, аж ахуй нэгж нийт 52 сая ширхэг хувьцааг эзэмшдэг байна. Цогтцэций сумаас баруун урагш

15 км зайд байрлах 5 жижиг толгойн нэрээр нэрлэгдсэн ажээ. Энэ таван жижиг толгойн нэг нь Цанхи юм. Цанхийн баруун, зүүн талыг “Эрдэнэс тавантолгой” ХК, төв хэсгийг ”Таван толгой” ХК ашигладаг байна. Жилд 5-15 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай, 8 дугаар давхаргад 51 жил, 4 дүгээр давхаргад 17 жил олборлолт явуулах төлөвтэй ба уурхайн гүн 73 м юм байна.

Хүмүүсийн аман яриагаар 4, 8 дугаар амнаас авсан нүүрс гэж ч хэлдэг ажээ. Уг уурхайгаас Өмнөговийн бүх сум, айл өрх, албан газрууд, Дорноговь, Дундговь аймгуудад коксжих, сул коксжих, коксжих чанаргүй, эрчим хүчний нүүрс зэргийг нийлүүлдэг байна. 2016 онд 36.2 сая тонн нүүрс олборлож байгаа нь өмнөх оны мөн үеэс 35 хувиар нэмэгджээ. Нүүрсний 2 төрлийн ачилт гүйцэтгэж байгаа нь борлуулалтын үр дүнг өсгөжээ. Уурхайгаас Цагаанхад боомт руу буулгахыг “уртын ачилт”, хилээр гараад Ганцмод боомт хүрэхийг “уртын урт ачилт” хэмээн нэрлэдэг болжээ. Тус компани нь Монгол Улсын нийт нүүрсний экспортын 13 хувийг эзэлдэг байна. 2016 онд 47.6 тэрбум төгрөгний ноогдол ашиг хувиарласан нь нийт ашгийн 90 хувь болж, Монгол Улсад хамгийн дээгүүрт орох үзүүлэлт болжээ. 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш 1 тонн тутамд төлсөн татварын хэмжээгээ 17.4 /Дараагийн байранд орж буй уурхай 9 ам.долларын татвар төлж байна/ ам.доллар байгаа нь улсдаа эхний байранд орох үзүүлэлт болж байна. Нийт 197 ажилтан, ажилчид байгаагаас 90 гаруй хувь нь Өмнөговь аймгийн иргэд байдаг ба бүх ажилчдыг монгол хүмүүсээс бүрдүүлжээ. Нэгж хувьцааны үнэ 900 гаруй мянган төгрөгт хүрэн хэт үнэд орсон тул нэгж хувьцааг 10 дахин задалснаар өнөөдөр 9500 орчим төгрөгийн ханштай болжээ. Ер нь жилийн эцсийн тайланг хараад ноогдол ашигаа найдвартай бөгөөд их хэмжээгээр тараадаг тул хүмүүс “Таван толгой” ХК-ийн хувьцааг ихээхэн сонирхож худалдан авдаг байна. Нийгмийн хариуцлагыг ухамсарлахын үүднээс дотооддоо 1 тонн тутмаас 20 гаруй мянган төгрөгний алдагдал хүлээж, 1 тонн нүүрсийг 13200 төгрөгөөр, улсдаа хамгийн хямдаар борлуулж байгаа гэнэ. Харин “МАК” ХК, “Энэржи ресурс” ХК зэргийн нүүрсний судлын налуу нь огцом байдаг тул зардал өндөр, олборлоход арай хүнд байдаг бол Цанхийн уурхайн нүүрсний судал налуу нь бага байдаг тул зардал хямд, олборлоход амар байдаг аж.

Одоохондоо Хятадын бага оврын машин механизм ашигладаг ч цаашдаа том оврийн техник технологийг ашиглах судалгаа явагдаж байгаа юм байна. 2009-2012 онд Өмнөговь аймгийн иргэн бүрд 500 мянган төгрөгийг баялагийн хишиг болгон хувааж өгсөн байна. Жишээ нь 5 ам бүлтэй айлд 2 сая 500 мянган төгрөгийг хүртээсэн гэсэн үг юм.

Өнөөдөр нүүрсний үнэ уурхайн аман дээрээ 67 ам.доллараар зарагддаг. Эдийн засгийн тооцооны үндсэн дээр олборлох, тээвэрлэх ажлыг Өмнөговийн гэрээт компаниудаараа хийлгэж, компанийн зүгээс үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилладаг байна.

Өмнөговь аймгийн өмнө тулгараад байгаа нэг том бэрхшээл бол ус болоод байгааг Д.Сэддорж захирал ярилаа. Түүний хэлснээр өнөөдөр тус аймгийн нутаг дэвсгэр дэх 120 метрийн гүн хүртэлх бүх худаг ширгэжээ. Хятадаас эмээж Хэрлэн голоос, Оросоос эмээж Орхон голоос ус татаж чадахгүй байсаар байтал Хятадын Хатан голын сав газарт Таван толгойн уурхайн бүх нүүрсийг угааж чадах хүчин чадалтай баяжуулах үйлдвэр баригдсан байна.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн тайланг уншиж байсан бидний зүгээс Монгол Улс гадаргын цэвэр усныхаа 5-хан хувийг ашиглаад үлдсэн 95 хувийг хил давуулан урсгадаг болохыг мэднэ. Усны асуудлаар мөнхийн гачигдалд байдаг говийн ард түмэн, Монгол Улсын төсөвт жинтэй хувь нэмэр оруулж байгаа уул уурхайн салбарынханы төлөөх цаашдын хөгжлийн гарцыг зөв харж, усны асуудлыг зоримогоор шийдвэрлэж чадахгүй байна. Энэхүү бодлогын алдаанаас үүссэн асуудалд харамсах сэтгэл өөрийн эрхгүй төрж байлаа.

Мөн өнөөг хүртэл “Оюу толгой” ХК-ийн хөрөнгө оруулалтаар Ханбогд суманд нэг ч байшин баригдаагүй бөгөөд 6 жилийн турш хэлэлцээр хийж байж, Оюу толгой ХК-тай хамтын ажиллагааны гэрээ хийсний үр дүнд Өмнөговь аймаг жилд 5 сая ам.доллар авдаг болсон тухай өгүүлснийг сонсоод Оюу толгойн гэрээ ашигтай, ашиггүй тухай ярьдаг нь ор үндэсгүй зүйл биш байж болох юм.

Түүнчлэн хилийн боомтын асуудалд бидний яриа шилжиж, манай талаас 17 цагт зорчигчдын хил хаах үеэр бөөнөөрөө Гашуунсухайтаас Хятадын Ганцмод руу уралдан гардаг тухай хачирхалтай зүйлийг сонсов. Учир нь усанд орох, хоол идэх, буудалд хонохын тулд хилээр

гардаг аж. Гэвч буцаад гарах үед сүлжээ тасарсан гэх мэт шалтгаар зорчигчдыг удаах, хонуулах зэргээр хүндрэл учруулдаг байна. Үүний гол шалтгаан нь хятадууд өөрсдийн боомтын худалдаа, үйлчилгээг дэмжих “зальжин” бодлоготой хамааралтай байж болохыг ч төвөггүй харж болохоор байсан юм.

Энэ бүхний эцэст төмөр зам, боомтынхоо хөгжлийг маргаж, тэнд монгол иргэд оршин амьдрах, үйлчлүүлэх ганц ч болтугай олон улсын жишигт ойртсон зочид буудал, зоогийн газар зэрэг үйлчилгээний салбарыг байгуулж чадахгүй байсаар байгаа манай төр засгийн бодлогын алдааг битүүдээ мэдэрч харамсах сэтгэл төрж байснаа нуух юун.

### **“Эрдэнэс таван толгой” ХК**

Бид цааш явсаар “Эрдэнэс таван толгой” ХК-ийн инженерүүдтэй уулзаж ярилцлаа. Цанхийн зүүн уурхай 785 сая тонн нүүрсний нөөцийг жилд 15 сая тонноор 30 жил ашиглах, баруун уурхай 840 сая тонн нөөцийг жилд 20 сая тонноор 30 жил ашиглах ТЭЗҮ батлуулсан. 2011 оноос хойш 32 орчим сая тонн нүүрс олборлож, 28 сая тонн нүүрс борлуулаад байна. Тус уурхай 493 ажилчидтай ба нэг ээлжиндээ 14 хоногт 200 гаруй хүн уурхайд ажилладаг байна. Одоогоор хөрс хуулалтын 2 компани үйл ажиллагаа явуулдаг. 50, 70 тоннын шанагатай экскаватртай. Нүүрсний үнэ аман дээрээ 68.1 ам.доллар. Зам тээврийн яамнаас энэ оны 10 дугаар сараас эхлэн квот тогтоожээ. Өөрөөр хэлбэл, 45 хувь нь Энэржи ресурс ХК, 40 хувь нь Эрдэнэс таван толгой ХК, 15 хувийг нь орон нутгийн Тавантолгой ХК тээвэрлэдэг болсон. Өмнө нь 1 хоногт 1200 гаруй машин хилээр гарж байсан бол одоо 500-600 орчим машин хил нэвтэрч тоо нь буурсан байна. 38 компанийн 5000 гаруй тээврийн хэрэгсэлээр нүүрс зөөж байна. Хятадын талаас өдөрт гаргах нүүрсний хэмжээнд хязгаар тогтоосон тул төмөр замаа тавиад ч нүүрсний машины урт дараалал багасахгүй болов уу. Жилд 13 сая тонн нүүрс олборлож байгаа боловч квоттой холбоотойгоор 6 сая тонн нүүрс борлуулж байна.

Компанийн удирдлага 100 хувь улсын өмчийн байгуулага. Чалко компанитай 1 тонн нүүрсийг 59.3 ам.доллараар борлуулах урт хугацааны гэрээтэй, бусад компанитай нээлттэй сонгон шалгаруулах

журмаар борлуулдаг. Өнөөдрийн байдлаар 1 тонн нүүрс ойролцоогоор 68 орчим ам.доллартай тэнцүү байна. Гэрээн дээрээ 1 куб метр нүүрс олборлох зардал 3.97-4.97 ам.доллар байдаг. Тавантолгойн ордын нийт 5 лицензийн талбай 68522 га байдгаас 95 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 3 хувийг “Энержи ресурс” ХК, 2 хувийг орон нутгийн “Таван толгой” ХК тус тус эзэмшдэг. Цанхийн зүүн уурхай дээр 5-18 м.куб шанагатай 10 ачигч техник, 50-240 тонн даацтай 40-50 тээвэрлэгч техник, зүүн уурхай дээр 12 ачигч техник, 70-80 тээвэрлэгч техник гэрээгээр ажиллаж байна. Метан хийний нөөцийн судалгаа хийсний үндсэн дээр бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж “Эрдэнэс Монгол Метан” хэмээх компани байгуулагдаж тусдаа гарчээ.

“Энержи ресурс” ХК-ийн инженерүүдийн яриа нь мөн л усны асуудал, төмөр зам өнөөг хүртэл баригдаагүй байгаагаас үүдсэн олон бэрхшээлүүд байсан юм.

### **“Энержи ресурс” ХК**

Тус компани нь дулааны цахилгаан станц, нүүрс баяжуулах үйлдвэртэй. 2009 оны 4 дүгээр сард үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлсэн. Жилдээ 15 сая тонн нүүрсийг Таван толгойн Ухаа худагаас олборлодог, улсын нүүрс олборлох томоохон уурхайнуудын нэг юм. Уурхай жилдээ 15 сая тонн нүүрс угаах хүчин чадалтай бүс нутагтаа томоохонд тооцогдох үйлдвэр болон 18 МВ-ийн хүчин чадалтай цахилгаан станц барьж, өнөөг хүртэл үйл ажиллагаа амжилттай явуулсаар байна.

Тус компани нүүрс баяжуулалтад ашигладаг усаа 500 метрийн гүний 12 худгаас авдаг ба газрын гүний эрдэсжилттэй усыг ундны усны стандартад хүртэл цэвэршүүлэх байгууламж, 56 мянган куб метрийн багтаамж бүхий усан сан, насос станц болон иж бүхэн автомат хяналтын систем бүхий бүрэлдэхүүн хэсгүүдийг ашиглаж байна. Мөн усны дутагдалтай говийн нөхцөлд нүүрс баяжуулалтын усны дахин ашиглалтыг 95 хувьд хүртэл өсгөж чадсан нь байгальд ээлтэй технологи болж чаджээ. Тус баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг өнөөгийн байдлаар залуу монгол инженер, ажилчид бүрэн хариуцаж, гадаадын мэрэгжилтэн, ажилтнууд огт байхгүй болсныг дуулаад эх орондоо хийж бүтээхийн оргилуун хүслээр жигүүрлэсэн, чадварлаг

залуусаараа бахархах сэтгэл төрж байлаа.

245 км хатуу хучилттай замыг Ухаа худаг, Гашуунсухайтын чиглэлд тавьж ашиглалтад оруулснаар орон нутгийн байгальд ихээхэн хохирол учруулан шороо тоос босгон давхилддаг, хэл амны бай болсон хэцүү асуудлыг шийдвэрлэж чаджээ. Барих, ашиглах, шилжүүлэх нөхцлийн хүрээнд 2014 оны 2 дугаар сард төрийн мэдэлд шилжүүлэн өгсөн байна.

Тавантолгойн нисэх буудал, 560 айлын бүрэн тавилгатай орон сууц, “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн цогцолбор зэрэг олон бүтээн байгуулалтыг компаний нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн байна. Өнөөг хүртэл 1.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. Түүнчлэн компаний ажилчдынхаа байр орон сууцны асуудлыг бүрэн шийдвэрлэж, залуус өмнийн говьдоо гэр бүлээрээ тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн сайн жишээ болсныг дурдах хэрэгтэй. Тус компани 2009-2015 онд улсын төсөвт 760 тэрбум төгрөгний орлого төвлөрүүлж, экспортын 2 тэрбум ам.долларын орлого улсад оруулсан байна. Мөн дотоодын 2700 гаруй аж ахуй нэгж ханган нийлүүлэгчээр, 10 гаруй мянган монголчуудаа шууд болон шууд бус ажлын байраар хангажээ.

### **Гашуун сухайгаас Ганц мод хүртэл**

Бид Цогтцэций суманд нэг хоноод Оюу толгой, нүүрс буулгадаг Цагаан хад, Гашуун сухайт, хилийн цаана байрлах БНХАУ-ын Ганцмод боомтоор зочилсон юм. Үнэхээр 150 гаруй км үргэлжлэх тус бүр 60 тонн нүүрс тээвэрлэсэн ачааны машины дэндүү гэмээр гайхал, хачирхал дагуулсан уртын урт цуваа хатуу хучилттай замаар эцэс төгсгөлгүй хөврөх ажээ. Урсгал сөрсөн, нүүрстэйгээ замын хажуу руу унасан, мөргөлдсөн зэрэг зүйлүүдийг харвал дайн болж буй мэт эвгүй сэтгэгдэл төрүүлмээр. Цөхөрсөн, уйдсан, залхсан жолооч нарын дүр зураг нүдэнд тусна.

Бидний томилолтын өмнөхөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам тээврийн сайдын хамт тус боомт дээр ажилласан юм. Энэ талаар мэдээллийн хэрэггэслээр хангалттай ярьж өгүүлсэн тул түр орхиод нүүрсний тээврийн уртын урт цуваа, түүний дагасан бэрхшээлүүд удахгүй арилахыг хүлээе.

Оюу толгойн зам нэртэй засмал зам байгаа боловч нүүрс ачсан том оврын машин явахыг хориглодог, торгодог юм байна. Мөн Оюутолгойн зам нэртэй зассан шороон зам байх бөгөөд зөвшөөрөлгүй бол мөн л явах эрхгүй. Нутгийн иргэдийн яриагаар өдөрт Оюутолгойн нэртэй зэсийн баяжмал ачсан 58 хүнд даацын машин хилээр гардаг аж. Тус уурхайг үзэж танилцахын тулд 7 хоногийн өмнө албан бичиг өгөх шаардлагатай байдаг гэсэн тул бид уурхайд очилгүй шууд Гашуунсухайтын боомтонд хүрэлцэн очлоо. Гашуунсухайтын боомтын хил дээр нүүрс ачсан том оврын ачааны машины урт дараалал, иргэдийг хилээр мөнгө авч гаргадаг машинууд, банштай цай зарна гэсэн хэдэн суудлын тэрэг, арилжааны банкуудын байрлах 1 давхар жижиг байшингаас өөр зүйл байсангүй. Ус, цахилгаан, буудал, хоолны газар, нийтийн бие засах газар зэрэг хүний наад захын хэрэгцээ хангах зүйлс байсангүй нь харамсмаар. Гашуун сухайтын боомтын дүр зураг ихээхэн гундуу санагдсан. Улс орны үүд хаалга бол хилийн боомт билээ. Өөдлөх айл үүд хаалганаасаа хэмээн ухаант өвөг дээдсийн минь мэргэн үг санаанд зэрэгцэн бууна. Бид боомтоо бодлогоор дэмжин хөгжүүлж, эх орынхоо үүд хаалгыг засах, шинэчлэн хөгжүүлэх цаг нэгт болсон бүр оройтсон байна гэж үзсэн.

Хилээр гарахад хүнд суртал ихтэй, олон цаг дараалалд зогсдог, алхах, зогсохыг хүртэл Хятадын талын хилийн ажилтнууд зааж зандарч байсан нь эвгүй сэтгэгдэл төрүүлэв. Гадаад паспортыг нэг бүрчлэн шалгаж, өөр өрөө рүү дуудан оруулж, та Япон, Герман, Орос, Энэтхэг, Солонгос руу яах гэж ямар ажлаар явж байсан бэ? гэхчлэн нэн бүдүүлэг, эрээ цээргүй асуултуудыг бидэнд тавьж байлаа.

Тээврийн жолооч нар болон монгол иргэдийг хилээр нэвтрүүлэхэд Хятадын боомтын ажилтнууд жинхэнэ утгаар нь “жижигрүүлж” байх аж. Хүнд суртлын талаар ярих нь илүүц. Үнэхээр авах хүн бөхийж, өгөх хүн гэдийхийн үлгэрээр монголчууд тэнд царай алдаж байхыг харахад нэн эмгэнэлтэй. Тус хилийн боомтын хүнд суртлыг арилгах талаар төр засгийн хэмжээнд Хятадын талтай яриа хэлэлцээ хийж анхаарах цаг нэгэнт болсон санагдав.

Харин Ганцмод хэмээх Хятадын боомт төсөөлөхөд манай Дархан хотын дайтай том хот болон ид бүтээн байгуулалтын үе дээрээ явж байна. Манай Гашуун сухайт боомттой харьцуулахын аргагүй зөрөөтэй.

Боомтын захиргаа нь манай Засгийн газрын ордныг ч дагуулахааргүй сүрлэг барилга. Өргөн, зам харгуйтай. Гашуунсухайтад жижиг гэр ч олддоггүй учраас монголчууд Ганцмод боомтод байр түрээслэн амьдардаг байна. БНХАУ-ын алс бөглүү хязгаарын энэ боомтын хөгжлөөс харахад хятадууд орон нутгаа хөгжүүлэх талаар төрийн бодлогын түвшинд анхаарч байгаа нь илт байлаа. Баялаг худалдан авч буй Ганц мод хөгжөөд байхад баялагаа худалдаж буй Гашуун сухайт хөгжил гэж харагдаж бүртийх ч юмгүй байгаа нь үнэхээр “Голланд өвчин” гэдэг нь туссаныг илтгэнэ.

### Дүгнэлт

Бид орон нутгийн томилолтоос үлдсэн дүгнэлт, санал бол орон нутгийн “Таван толгой” ХК шиг улсын 51%, хувийн 49%-ийн эзэмшилтэй байх сонголт хамгийн үр дүнтэй, улсад болон хувийг секторуудад ашигтай харагдлаа. Тиймээс стратегийн орд газруудыг 51:49 гэсэн загвараар цаашид ашиглах талаар түлхүү судалж үзэх нь зүйтэй байна.

Байгалийн баялаг ихтэй орон нутгаас байгалийн баялаг багатай орон нутаг руу хөрөнгийн урсгал явагдаж байгаа нь талуудын идэвх, санаачлагыг нь бууруулж байна. Хэрэв орон нутагт нь эрх мэдлийг нь өгвөл байгалийн баялаг ихтэй нь ч, байгалийн баялаг багатай нь ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж цаашид хөгжих боломж нээгдэхээр байна. Ажилсаг хөдөлмөрч зарим нь өдөр шөнөгүй зүтгэж, аймаг орон нутгийнхаа байгалийг золиослон байж олсон орлогоо улсын төсөв рүү хуу хамуулж, залхуу татаас нэхдэг зарим аймгуудыг “тэжээж” тэдний бэлэнчлэх сэтгэлгээг архагшуулж байгаа нь шударга бус сонголт юм.

Өнөөг хүртэл устай мөрөнтэй аймгуудаас сонгогдсон улс төрчид говийн ард түмнээс усаа “харамлах” нутгархаг бодлого баримталсан хэмээн тэд гомдож байна. Монгол Улсын баялаг бүтээгч нар усны гачаалтай хэвээр байна.

Мөн хил орчмын нутгуудын хөгжлийн бодлогыг боловсронгуй болгоогүйгээс валютын асар их урсгалыг гадагшаа алдаж байна. Гашуунсухайт, Ганцмодны хөгжлийг харьцуулахад л харамсмаар жишээг харж болно.

Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр төмөр замыг Тавантолгойн уурхайгаас өмнө чигт Гашуунсухайт, зүүн чигт Сайншанд руу байгуулах эрх өгөх нь хялбар шийдэл болох боломтой байна.

Хэрлэн, Орхон голын ойролцоо усан сан байгуулж, үержилт ихтэй үед усыг нөөцлөн авч дээрх голуудын экологид сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байдлаар мэргэжлийн эрдэмтдийн зөвлөмжийн дагуу усны хоолой татаж говийн бүсийн уул уурхай, газар тариалан, мал аж ахуйгаа дэмжих шийдвэрийг төр засгаас зоримогоор гаргах цаг болжээ. Ингэснээр говийн бүсэд жинхэнэ ногоон хэрэм байгуулах, гүний усны хэрэглээг багасгаж, Монгол орныхоо байгалийг хамгаалахад чухал нөлөөлөл үзүүлэхээс гадна уул уурхайн салбарт, тухайлбал ганц нүүрс баяжуулалтаар л авч үзэхэд орлогыг хэд дахин нэмэгдүүлж, улс орны эдийн засагт үр дүнтэй алхам болж чадахаар байна.

Уул уурхайн үндэсний боловсон хүчнийг чадавхжуулах зорилгын үүднээс улсын их, дээд болон мэргэжлийн сургуулиудаас сонгож, салбар сургуулийг Цогтцэций суманд байгуулбал оюутнууд уул уурхай дээр анхнаасаа дадлага хийх, цаашид ажиллахад боломж нээгдэж, тэднийг мэргэжлийн чиглэлээрээ чанартай боловсрол эзэмшихэд түлхэц болохоор байна.

Монгол Улсын банкны системийг сайжруулан, чадавхжуулах уул уурхайгаас орж ирэх ихээхэн орлогыг Монгол улсад төвлөрүүлдэг болох хууль эрх зүйн орчинг эртнээс бий болгох шаардлага тулгарч байна.

Цаашид дээрх тулгамдсан асуудлуудыг илүү гүнзгий судлах, боловсруулах, сайжруулах, хөгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ чиглэлд төр засаг, орон нутаг, компани, иргэдийн хувьд хамтран ажиллах, хийж бүтээх олон зүйл байгааг орон нутгийн энэхүү томилолтын хүрээнд анзаарч харлаа.

“Мянга сонсохоор нэг үз” гэсэн ардын мэргэн үгээр бид үзсэн, харсан олон зүйлийн нэгээхэн хэсгийг та бүхэндээ танилцуулахад ийм байна. Алдаа оноотой зүйл байх аваас та бүхэн хэлтрүүлэн уучлах буй за.

Наран ээсэн баялагийн ундаргат эх орны минь үүд хаалга болсон өмнийн говийн ажилч хөдөлмөрч, халуун сэтгэлтэй ард түмнийхээ дунд дахин зочлохын өлзийт ерөөлийг дэвшүүлье.